



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 17

Жаргалант

Г Нийгмийн эрүүл мэндийн төлөвлөгөө Г
батлах тухай

Сумын нийгмийн Эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн 2014 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


Хоёр. Төлөвлөгөөнд туссан ажлуудыг цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2015 оны 1 сард багтаан ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн дарга, орлогч дарга нарт даалгасугай.



ДАРГА  Д.ГАНТӨМӨР

1513134

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар тогтоолын хавсралт



**ЖАРГАЛАНТ СУМЫН “НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ” – ИЙН
2014 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийгдэх ажил	Хэрэгжих хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР					
1	Гудамж хорооллын иргэдийг тогтмол орчны цэвэрлэгээнд гаргаж, хөрсний бохирдолтоос сэргийлэх .	Тогтмол	<ul style="list-style-type: none"> - 4 багийн иргэд - Төрийн болон төрийн бус байгууллага - Хувийн хэвшилүүд 	Д. Далхаа Байгаль орчны улмын байцаагч Байгаль хамгаалагчид Багийн дарга нар Сум дундын эмнэлэг Олон нийтийн байцаагч	Гудамж хорооллыг тогтмол орчны цэвэрлэгээнд гаргаснаар хөрсний бохирдолтгүй болсон байна.
2	Мэргэжлийн хяналтын газарт сургууль, цэцэрлэг, сум дундын эмнэлэг зэрэг байгууллагуудын хөрснөөс дээж авч явуулах	1-р улирал	<ul style="list-style-type: none"> - Сургууль - Цэцэрлэг - Сум дундын эмнэлэг 	Байгууллагын эрхлэгч нар	Мэргэжлийн хяналтын газарт хөрсний дээжийг явуулж, хөрсийг шинжлүүлсэн байна.
3	Сумын төвийн айл өрхүүдийн стандартын бие засах газар бохир усны цооногийн судалгааг гаргаж стандартын бие засах газар бохир усны цооногтой болох хөдөлгөөн өрнүүлэх	4 - 10 сар хүртэл сард	- Сумын иргэд	Багуудын засаг дарга Олон нийтийн байцаагч Гудамж хариуцсан ажилчид Орчны эрүүл мэндийн хөтөлбөр хариуцагч	Судалгаа хийж, сумын нийт айл өрхийг стандартын бие засах газар бохир усны цооногтой болгосон байна.

4	Гудамж хороололд бохир ус ил задгай асгаж буй айл өрхүүдэд сануулга өгөх, зураг авах, бичлэг хийх, цаашид авах арга хэмжээг танилцуулах, ухуулга сурталчилгаа хийх	Тогтмол	- Сумын иргэд	Багуудын засаг дарга Олон нийтийн байцаагч Байгаль хамгаалагч Соёлын төвийн эрхлэгч	Гудамж хороололд бохир ус ил задгай асгаж буй айл өрхийн тоо буурсан байна.
5	Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, цэвэр эрүүл орчинд амьдрах хэвшлийг иргэдэд олгох	Сар бүрийн 2, 4 дэх 7 хоногт	- Сумын иргэд	НЭМСЗ – ийн гишүүд НЭМА Багуудын засаг дарга Байгаль хамгаалагчид	Орчны бохирдол буурч, иргэд цэвэр эрүүл орчинд амьдрах хэвшилтэй болсон байна.
6	Хөдөөгийн айл өрхүүд өвөлжөө, хаваржаандаа бие засах газар болон бохир усны цооногтой болох, нүүхдээ ойр орчмын хогийг цэвэрлэж хэвших.	Тогтмол	- Багийн иргэд	Багуудын засаг дарга Багийн эмч нар Байгаль хамгаалагчид	Бие засах газар, бохир усны цооногтой болж, нүүхдээ ойр орчмын хогийг цэвэрлэж хэвшсэн байна.
7	Малын хашаа хороог ариутгах, малыг тарилга, туулганд тогтсон цаг хугацаанд нь хамруулах.	Товлолын дагуу	- Багийн иргэд	Багуудын засаг дарга Багуудын малын эмч нар	Хашаа хороог ариутгаж, малыг тарилга, туулганд тогтсон цаг хугацаанд нь хамруулж хэвшинэ.
8	Гудамж хорооллыг хариуцсан сайн санааны идэвхитэнтэй болгох	4 сард	- Сумын иргэд	БОХУБайцаагч Багийн засаг дарга Байгаль хамгаалагч НЭМСЗ – ийн гишүүд	Гудамж хороололд сайн санааны идэвхитэнг томилж хариуцуулснаар нэгдсэн зохион байгуулалттай болсон байна.
ХҮНС ХӨДӨӨ АЖ АХҮЙН ТАЛААР					
1	Малаас хүнд халдварладаг Зооноз өвчнүүдийн талаар сургалт явуулж гарын авлага, бэлтгэж тараах	1-р улиралд	- Сумын нийт иргэд	ХХАА – н мэргэжилтэн С. Жаргалсайхан Багуудын засаг дарга Халдвар хяналтын баг	Малаас хүнд халдварладаг Зооноз өвчнүүдийн талаар тодорхой мэдлэгтэй болсон байна.

2	Махан болон сүү сүүн бүтээгдэхүүн, хүнсний эрүүл ахуйн, аюулгүй байдал, техникийн шаардлага стандартыг мөрдөх Гарал үүслийн бичгийг шалгаж хэвших. Төв суурингийн газрын хүн амыг эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдалд бэлтгэгдсэн хүнсний бүтээгдэхүүнээр хангах, үйлчлэх, хяналт шалгалт хийх .	Тогтмол	- Сумын төвийн иргэд	ХХАА – н мэргэжилтэн С. Жаргалсайхан	Иргэдийг эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдалд бэлтгэгдсэн хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөл сайжирсан байна.
3	Бага насны хүүхдийн зөв зохистой хооллолтын талаар эхчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх	Улиралд 1 удаа	- Эцэг эхчүүдэд	ХХАА – н мэргэжилтэн С. Жаргалсайхан Хөтөлбөр хариуцагч Д. Алтанчимэг	Нялхасын хооллолтын талаархи эхчүүдийн мэдлэг дээшилсэн байна.
4	Өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх	Тогтмол	- Сумын иргэд	ХХАА – н мэргэжилтэн С. Жаргалсайхан Хөтөлбөр хариуцагч Д. Алтанчимэг	Айл бүр иоджуулсан давс хэрэглэж хэвшсэн байна.
5	Иргэдэд зөв зохистой хооллох дадал хэвшлийг олгох, хүнсний аюулгүй байдалд олон нийтийн байгууллага, иргэдийг идэвхитэй оролцуулах .	Тогтмол	- Сумын иргэд	ХХАА – н мэргэжилтэн С. Жаргалсайхан Хөтөлбөр хариуцагч Д. Алтанчимэг	Иргэдэд зөв зохистой хооллодог, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьдаг болсон байна.
ЕБС БОЛОВСРОЛЫН ТАЛААР					
1	Багш, суралцагч, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан	1, 4 – р сард	- ЕБС – ийн багш,	Сум дундын эмнэлэг Сургуулийн эмч	Багш, суралцагч, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан

	сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах		ажилчид, сурагчид		сэргийлэх үзлэгт хамруулсан байна.
2	“Хоггүй цэвэр орчин” хөдөлгөөнийг өрнүүлж ажиллах.	3,4 – р сард	- ЕБС – ийн багш, ажилчид, сурагчид	“Байдраг” ахлах сургууль	“Хоггүй цэвэр орчин” бүрдсэн байна.
3	“Үдийн цай” хөтөлбөр, байрны сурагчдын хоолны хүртээмж, тэжээллэг чанар эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах .	Тогтмол	- Бага ангийн сурагчид - Байрны сурагчид	НЭМСЗ Сургуулийн захиргаа ЗДТГ – ын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбар зөвлөлийн ажилтан	Хоолны хүртээмж, тэжээллэг чанар сайжирсан байна.
4	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох зорилт тавин ажиллаж буй байгууллагуудтай хамтарч ажиллах .	Жилдээ	- Албан байгууллагууд	Сургуулийн захиргаа	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон байна.
5	“Эрүүл орчин” “Эрүүл харилцаа” – г бүрдүүлэхэд “Эко” орчин, мэндлэх, хүндлэх ёсыг хэвшүүлэх, дэг тогтоох	3, 4 – р сард	- Сургуулийн хамт олон	Сургуулийн захиргаа	Эрүүл орчин, эрүүл харилцааг бүрдүүлсэн байна.
6	Сургуулийн хамт олонд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах.	5 – р сард	- Сургуулийн багш, ажилчид, сурагчид	Сургуулийн эмч НЭМСЗ Сум дундын эмнэлэг	Сургуулийн хамт олонд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх МСС – г хийснээр тэдний мэдлэг дээшилсэн байна.
7	Сурагчдын дунд шүдний өвчлөл их байгаатай холбогдуулан мэргэжлийн эмч ажиллуулах .	Жилдээ	- Сургуулийн сурагчид	Сургуулийн захиргаа НЭМСЗ	Шүдний өвчлөл буурсан байна.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР

1	Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах.	9 сард	- Цэцэрлэгийн хүүхдүүд	Сум дундын эмнэлэг Цэцэрлэгийн эрхлэгч	Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.
2	Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг витаминжуулалтын аян зарлах .	Улиралд 1 удаа	- Цэцэрлэгийн хүүхдүүд	Цэцэрлэгийн эрхлэгч Багш нар	Цэцэрлэгийн хүүхдүүдийг улиралд витаминжуулж хэвшсэн байна.
3	Багш ажилчдыг улиралд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах .	Аймагт 2, Сумд 2 удаа	- Цэцэрлэгийн багш, ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч Сум дундын эмнэлэг	Багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.
4	Хоггүй орчинг бий болгох .	7 хоног бүр	- Цэцэрлэгийн багш, ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч	Хоггүй орчинг бий болгосон байна.
5	Аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлж ажиллах.	Жилдээ	- Цэцэрлэгийн багш, ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч	Аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлсэн байна.
6	Анхны тусламжийн буланг тогтмол хэрэглэж хэвших .	Тогтмол	- Цэцэрлэгийн багш, ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч Сум дундын эмнэлэг	Анхны тусламжийн булантай болсон байна.
7	Анги бүлэг бүр чийрэгжүүлэлтийн булантай болох .	Жилдээ	- Цэцэрлэгийн багш, ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч Сум дундын эмнэлэг	Чийрэгжүүлэлтийн булантай болсон байна.
8	Хүүхдийн жингийн дутагдлаас сэргийлэх, “Гал голомт” төсөлтэй хамтарч ажиллах .	Тогтмол	- Цэцэрлэгийн багш ажилчид, хүүхдүүд	Цэцэрлэгийн эрхлэгч Сум дундын эмнэлэг	Гэр цэцэрлэгт гарч хүүхдүүдийг чийрэгжүүлсэн байна.
9	Ажилчдаар ажлын байрны дасгалыг тогтмол хийлгэж хэвшүүлэх .	Тогтмол	- Цэцэрлэгийн багш ажилчид	Цэцэрлэгийн эрхлэгч Сум дундын эмнэлэг	Ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн байна.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ХӨДӨЛМӨРИЙН ТАЛААР

1	Эмгэнт дахь байрыг	Жилдээ	- Сумын иргэд	ЗДТГ	Чийрэгжүүлэлтийн байрыг
---	--------------------	--------	---------------	------	-------------------------

	засварлаж, чийрэгжүүлэлтийн байр болгон ажиллуулах.			Сум дундын эмнэлэг	ашиглалтанд оруулсан байна.
2	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлэх, дэмжигч байгууллагуудын шатлалыг ахиулах .	Жилдээ	- Цэцэрлэг, сургууль, СДЭ, ЗДТГ	Байгууллагын менежерүүд НЭМА	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлж, дэмжигч байгууллагуудын шатлалыг ахиулсан байна.
3	Төсөвт байгууллагуудын ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах .	Жилдээ	- Төсөвт байгууллагын хортой, хүнд нөхцөлд ажилладаг ажилчид	Байгууллагын эрхлэгч нар Д. Ганзориг Үйлдвэрчний эвлэл	Байгууллагуудын ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулсан байна.
НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖИЙН ТАЛААР					
1	Иргэд, даатгуулагчдад “Иргэний эрүүл мэндийн хууль” – ийн талаар сургалт хийх.	Улирал бүр	- Сумын иргэд	НД – ын байцаагч Их эмч Г. Алтанхуяг	Иргэд, даатгуулагч “Иргэний эрүүл мэндийн хууль” – ийн талаар мэдлэгтэй болсон байна.
2	Иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах .	Тухай бүр	- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд	НД – ын байцаагч Багуудын засаг дарга Багийн эмч	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан байна.
3	Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах.	Тухайн жилд	- Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүд	НД – ын байцаагч Багуудын засаг дарга Багийн эмч	Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулсан байна.
4	“Байдраг” ахлах сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд	5 сард	- Ахлах ангийн сурагчид	НД – ын байцаагч Сургуулийн НА	Сурагчдын дунд “Ирээдүйгээ даатгая” сэдэвт сургалт явуулж,

	засварлаж, чийрэгжүүлэлтийн байр болгон ажиллуулах.			Сум дундын эмнэлэг	ашиглалтанд оруулсан байна.
2	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлэх, дэмжигч байгууллагуудын шатлалыг ахиулах .	Жилдээ	- Цэцэрлэг, сургууль, СДЭ, ЗДТГ	Байгууллагын менежерүүд НЭМА	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлж, дэмжигч байгууллагуудын шатлалыг ахиулсан байна.
3	Төсөвт байгууллагуудын ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах .	Жилдээ	- Төсөвт байгууллагын хортой, хүнд нөхцөлд ажилладаг ажилчид	Байгууллагын эрхлэгч нар Д. Ганзориг Үйлдвэрчний эвлэл	Байгууллагуудын ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулсан байна.
НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖИЙН ТАЛААР					
1	Иргэд, даатгуулагчдад “Иргэний эрүүл мэндийн хууль” – ийн талаар сургалт хийх.	Улирал бүр	- Сумын иргэд	НД – ын байцаагч Их эмч Г. Алтанхуяг	Иргэд, даатгуулагч “Иргэний эрүүл мэндийн хууль” – ийн талаар мэдлэгтэй болсон байна.
2	Иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах .	Тухай бүр	- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд	НД – ын байцаагч Багуудын засаг дарга Багийн эмч	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан байна.
3	Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах.	Тухайн жилд	- Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүд	НД – ын байцаагч Багуудын засаг дарга Багийн эмч	Хөдөлмөрийн насны болон төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулсан байна.
4	“Байдраг” ахлах сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд	5 сард	- Ахлах ангийн сурагчид	НД – ын байцаагч Сургуулийн НА	Сурагчдын дунд “Ирээдүйгээ даатгая” сэдэвт сургалт явуулж,

	“Ирээдүйгээ даатгая” сэдэвт сургалт явуулж, АХА тэмцээн зохион явуулах .				АХА тэмцээн зохион явуулсан байна.
5	Иргэд, даатгуулагчдад Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын талаар мэдээлэл хүргэж, даатгалтай иргэдэд хөнгөлөлттэй эмээр үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах .	Тогтмол	- Даатгуулагч иргэд	НД – ын байцаагч Багийн эмч ЭЭС – ийн эрхлэгч	Иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хөнгөлөлттэй жороор үйлчлүүлдэг болсон байна.
6	Өсвөр үеийн чуулган зохион байгуулах .	4 – р сард улиралд	- Өсвөр үеийнхэн	Нийгмийн түншлэлийн баг	Өсвөр үеийн чуулган зохион байгуулсан байна.
7	Залуучуудын чуулган зохион байгуулах	3 - р улиралд	- 18 – 35 насны залуучууд	Нийгмийн түншлэлийн баг	Залуучуудын чуулган зохион байгуулсан байна.
8	Ахмад настны чуулган зохион байгуулах	2 – р улиралд	- Ахмадууд	Нийгмийн түншлэлийн баг	Ахмад настны чуулган зохион байгуулсан байна.
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган зохион байгуулах	3 – р улиралд	- ХБ – тэй иргэд	Нийгмийн түншлэлийн баг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган зохион байгуулсан байна.
10	Эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулах	3 – р улиралд	- Эмэгтэйчүүд	Нийгмийн түншлэлийн баг	Эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулсан байна.
11	Эрэгтэйчүүдийн сургалт зохион байгуулах	4 – р сард	- Эрэгтэйчүүд	Нийгмийн түншлэлийн баг	Эрэгтэйчүүдийн сургалт зохион байгуулсан байна.
12	Гэрийн ажилтай эмэгтэйчүүдэд сургалт хийх, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	2 – р улиралд	- Гэрийн эзэгтэй нар	Нийгмийн түншлэлийн баг	Гэрийн ажилтай эмэгтэйчүүдэд сургалт хийж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
13	Сургууль төгсөөд ажил эрхлээгүй залуучуудад сургалт хийх, нээлттэй	2 – р улиралд	- Ажил эрхлээгүй эмэгтэйчүүд	Нийгмийн түншлэлийн баг	Сургууль төгсөөд ажил эрхлээгүй залуучуудад сургалт хийж, нээлттэй хэлэлцүүлэг

	хэлэлцүүлэг зохион байгуулах				зохион байгуулсан байна.
14	Ахмад настан, ХБИ – ийг асарч буй иргэнд сургалт хийх, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	4 сард	- Асран хамгаалагч	Нийгмийн түншлэлийн баг	Ахмад настан, ХБИ – ийг асарч буй иргэнд сургалт хийж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ					
1	“Хүн бүр хүүхдийн төлөө санаачлага гаргацгаая” аян зохион байгуулах	Жилдээ	- Сумын иргэд - Төсвийн байгууллагын ажилчид	Сумын засаг дарга БОХУБайцаагч Багуудын засаг дарга Байгаль хамгаалагч НЭМСЗ – ийн гишүүд	“Хүн бүр хүүхдийн төлөө санаачлага гаргацгаая” аяныг зохион байгуулж үр дүнг тооцсон байна.
2	“Цэмцгэр хашаа” аяны удирдамжыг гаргаж, оны эцэст “Шилдэг гудамж, хороолол” – ыг шалгаруулж, урамшуулах.	Жилдээ	- Сумын иргэд	БОХУБайцаагч Багийн засаг дарга Байгаль хамгаалагч НЭМСЗ – ийн гишүүд	“Шилдэг гудамж, хороолол” – ыг шалгаруулж, урамшуулсан байна.
3	“Алхалт бидний эрүүл мэндэд” явган аялалыг зохион байгуулах	6 сард	- Сумын иргэд - Төсвийн байгууллагын ажилчид	Сумын засаг дарга ҮЭ – ийн холбооны тэргүүлэгчид	“Алхалт бидний эрүүл мэндэд” явган аялалыг зохион байгуулсан байна.
4	Ажлын байрны дасгалыг төрийн болон төрийн бус байгууллагын ажилчдаар тогтмол хийлгэж хэвших, дулааны улиралд нэгдсэн хэлбэрээр тусгай талбайд хийж байх	Жилдээ	- төрийн болон төрийн бус байгууллагын ажилчид	Сумын засаг дарга Байгууллагуудын эрхлэгч НЭМСЗ – ийн гишүүд Багуудын засаг дарга	Ажлын байрны дасгалыг тогтмол хийлгэж хэвшүүлсэн байна.
5	“Цэвэр агаар идэвхитэй хөдөлгөөн” цас мөсний баярыг зохион байгуулах.	3 сард	- төрийн болон төрийн бус байгууллагын ажилчид	Сумын засаг дарга Байгууллагуудын эрхлэгч НЭМСЗ – ийн гишүүд ҮЭ – ийн холбооны	“Цэвэр агаар идэвхитэй хөдөлгөөн” цас мөсний баярыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.

				тэргүүлэгчид	
6	Сайныг дэмжье, саарыг жигшье мэдээллийн самбар гаргах .	Тогтмол	- Сумын иргэд - төрийн болон төрийн бус байгууллагын ажилчид	НЭМСЗ – ийн гишүүд ҮЭ – ийн холбооны тэргүүлэгчид	Мэдээллийн самбар гаргаж, иргэдийг тогтмол мэдээллээр хангадаг болсон байна.
7	“Байдраг голоо аврая” ажлын төлөвлөгөө боловсруулж, мөрдөх.	Жилдээ	- Сумын иргэд	Сумын засаг дарга БОХУБайцаагч Багуудын засаг дарга Байгаль хамгаалагч НЭМСЗ – ийн гишүүд	Төлөвлөгөөний дагуу ажиллаж, үр дүнг тооцсон байна.
8	“Гэр бүлийн өдөр” – өөр өрх толгойлсон эцэг, эх болон бүтэн, хагас өнчин хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, сургалт хийх .	5 – р сард	- өрх толгойлсон эцэг, эх - бүтэн, хагас өнчин хүүхдүүд	НЭМСЗ – ийн гишүүд Багуудын засаг дарга Багийн эмч нар Сум дундын эмнэлэг	Өрх толгойлсон эцэг, эх болон бүтэн, хагас өнчин хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, тэдний ЭМБО – г дээшлүүлсэн байна.
ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР					
1	Иргэний танхимд “Эрүүл мэндийн багц хууль” болон эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт сурталчилгааны хүрээнд сар бүр 3 сэдвээр сургалт хийх.	7 хоногийн 4 дэх өдөр	- Сумын иргэд	Сум дундын эмнэлгийн эмч, дунд мэргэжилтэн	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна.
2	Дээд шатлалын эмнэлэгт зайлшгүй эмчлүүлэх эх, нярайд шаардагдах зардлын тодорхой хувийг тооцоолон орон нутгийн төсөвт тусгаж гаргах, ЗД – ын нөөцөөс гаргах асуудлыг шийдвэрлүүлэх.	Жилдээ	- Эх, нярай	ЗДТГ Засаг дарга Ерөнхий эмч Нягтлан бодогч	Дээд шатлалын эмнэлэгт зайлшгүй эмчлүүлэх эх, нярайд шаардагдах зардлыг тооцоолон орон нутгийн төсөвт тусгаж, ЗД – ын нөөцөөс гаргах асуудлыг шийдвэрлэсэн байна.
3	Бага насны хүүхдийг ахуйн	2.3,4 – р	- Цэцэрлэгийн	Мэс заслын эмч	Ахуйн осол гэмтэл буурна.

	ослоос сэргийлэх талаар бүх нийтийг хамарсан сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	улиралд	багш, ажилчид, эцэг эхчүүдэд	НЭМА Цагдаагийн хэсэг	
4	Сэтгэцийн эмгэг, архи, тамхи, мансууруулах бодис, компьютерт донтохоос сэргийлэх чиглэлийн сурталчилгааг ЕБС – ийн сурагчдын дунд зохион байгуулах.	1, 3 – р улирал	- ЕБС – ийн сурагчдад	Сургуулийн нийгмийн ажилтан НЭМА	Сэтгэцийн эмгэг, архи, тамхи, мансууруулах бодис, компьютерт донтохоос сэргийлэх чиглэлээр сургалт хийснээр сурагчдын мэдлэг дээшилсэн байна.
5	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа 14 хөтөлбөр, 18 стратегийн хэрэгжилтэнд хяналт тавих.	Жилдээ	- Сумын иргэд	Ерөнхий эмч НЭМА	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа 14 хөтөлбөр, 18 стратегийн хэрэгжилт сайжирсан байна.
6	Эрүүл зан үйл 21 хөтөлбөрийг сурталчилах өдөрлөгийг хөдөөгийн багуудад зохион байгуулах .	2 – р улиралд	- Сумын иргэд	Сум дундын эмнэлгийн эмч, дунд мэргэжилтэн, ажилчид	Иргэдийн мэдлэг дээшилж, хандлага өөрчлөгдөнө.
7	Эрүүл мэндийн багц хуулийг сурталчлах жилийн аяны хүрээнд сар бүр 1 хуулиар төлөвлөгөө боловсруулан, ажиллах .	Сар бүр	- Сумын иргэд	Хариуцсан эмч, мэргэжилтэнгүүд	Иргэдийн хуулийн мэдлэг дээшилж, эрх үүргээ мэддэг болно.
8	“Эрүүл мэндийг дэмжигч өрх – гэр бүл” болзолт уралдаан зарлаж, шалгаруулах, шагнаж урамшуулах, алдаршуулах .	Жилдээ	- Айл өрх бүр	НЭМСЗ	Эрүүл мэндийг дэмжигч өрхийн тоо нэмэгдсэн байна.
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР					
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг графикайн дагуу багуудад	Жилдээ	- Сумын нийт иргэд	НЭМСЗ Цагдаагийн хэсэг Багийн ИТХ- ын	Гэмт хэргийн гаралт багасна.

	сургалт хийх, мэдээллээр хангах			дарга Багийн засаг дарга нар	
2	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталилгаа хийх .	Жилдээ	- Сумын нийт иргэд	Цагдаагийн хэсэг Сум дундын эмнэлэг	Осол гэмтлийн үзүүлэлт буурсан байна.
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО					
1	Нийтийн биеийн тамирыг дэмжих зорилгоор бүх нийтээр гүйдэг өдөртэй болох .	Сард 1 удаа	- Сумын нийт иргэд - Албан байгууллагын ажилчид	НЭМСЗ	Нийтээр сард нэг удаа гүйж хэвшсэн байна.
2	Иргэдийг стресс тайлах аргад суралцуулах, бясалгал хийлгэх .	Тогтмол	- Сумын нийт иргэд	НЭМСЗ	Иргэд стрессээ зөв тайлах чадварт суралцсан байна.
3	“Эмэгтэйчүүдээ, эрүүл мэндээрээ манлайлая” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	6 сард	- Нийт эмэгтэйчүүд	НЭМСЗ	Эрүүл байх зан үйлд суралцсан байна.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 онь 03 сарын 24 өдөр

Дугаар 18

Жаргалант

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 2014 онд суманд хэрэгжүүлэх бэлчээрийн эрсдлийн менежментийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, хөрөнгө санхүүгийн асуудлыг шуурхай шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/, мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Д.Дашхүү/ нарт даалгасугай.



ДАРГА *[Signature]* Д.ГАНТӨМӨР

1513135

togtool-2014

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 18 дугаар тогтоолын хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН 2014 ОНЫ БЭЛЧЭЭР
ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Зохион байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зардлын санхүүжилт
Нийтлэг арга хэмжээ				
1	Мал аж ахуйн салбарын зөвлөгөөн, сургалт зохион байгуулах	1 дүгээр улиралд	ЗДТГазар, МЭУТасаг	
2	Малчдыг хоршоонд хамруулах нэг баг, нэг хоршоо хөдөлгөөн өрнүүлж хоршоо байгуулах, дэмжлэг үзүүлэх	Эхний хагас жилд	ЗДТГазар Багийн малчид	
3	Малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнийг хоршоонд өгөх, анхан шатны тордолт хийж хоршоо, биржээр дамжуулан улсын үйлдвэрт нийлүүлэх	Жилдээ	Хоршоо Малчид	Өөрийн хоршоо
4	Улсад тушаасан бүтээгдэхүүний хэмжээгээр урамшуулалд хамруулах арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	Хоршоо МЭУТасаг	
5	Өвлийн бэлтгэл хангах албан даалгавар гаргах, шалгаж хүлээн авч нэгтгэн дүгнэж аймагт хүргүүлэх	7-10 дугаар сард	Засаг дарга Багийн Засаг дарга нар	
Тэжээл бэлтгэх, нөөцлөх, нөхөн хангах арга хэмжээ				
1	Өрхийн хадлан, тэжээл бэлтгэх /хонин толгой шилжүүлснээр нэг хонин толгойд 10 кг өвсөөр бодож нийт малчдаар хадлан бэлтгүүлэх/	7,8,9 дүгээр сард	ЗДТГазар МЭУТасаг Багийн Засаг дарга нар	Өөрийн хүчээр
2	Боломжтой малчид ногоон тэжээл тариалах, гар ба сувилалын тэжээл бэлтгэх	5, 7, 8, 9 дүгээр сард	Багийн Засаг дарга нар Малчид	Өөрийн хүчээр
3	Гамшигаас хамгаалах тэжээлийн сумын нөөц, фонд бүрдүүлэх, зарцуулах	7,8,9 дүгээр сард	Засаг дарга МЭУТасаг	Хөрөнгө тусган хэрэгжүүлэх
4	Багийн төвд тэжээл хадгалах байнгын цэг байгуулж нөөц бүрдүүлэх	2,3 дугаар улиралд	Сум, багийн Засаг дарга нар	Хөрөнгө тусган хэрэгжүүлэх
Усан хангамжийг сайжруулах, усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ				
1	Шинээр худаг гаргах, сэргээн засварлах арга хэмжээг хэрэгжүүлэх	2,3 дугаар улиралд	Сум, багийн Засаг дарга нар МЭУТасаг	Хөрөнгө тусган хэрэгжүүлэх
2	Шинээр гаргасан, засварласан худгийг малчны бүлэг, ашиглагчдад эзэмшүүлэх	3,4 дүгээр улиралд	Сум, багийн Засаг дарга нар МЭУТасаг	

Отрын ба нөөц бэлчээр нутаг ашиглах, хамгаалах арга хэмжээ авах				
1	Мал ногоолуулах, зун намрын отор хийх, нутгаа хуваарьтай ашиглах, шийдвэр эрхийн акт гаргах	3 дугаар улиралд	Сум, багийн Засаг дарга нар Багийн ИНХурал	
2	Нөөц бэлчээрийг зөвшөөрөлгүй ашиглах, бусад аймаг сумын иргэд ашиглах, дайран өнгөрөхөөс хамгаалах	Байнга	Сум, багийн Засаг дарга нар	
Мал оторлох арга хэмжээг зохион байгуулах				
1	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт өвөлжөө, хаваржаа эзэмшиж байгаа иргэдийн эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох	Жилдээ	Сум, багийн Засаг дарга ТХГНутгийн байгаль хамгаалагч	
2	Хашаа хороо засварлах, шинээр барих, гар худаг засварлах, хувийн бэлтгэлээ хангах	Жилдээ	Бүх малчид	Өөрийн хүчээр
3	Баг бүр отрын нөөц нутагтай болох	1 дүгээр улиралд	Багийн Засаг дарга нар	
4	Цаг хүндэрсэн үед отрын нутагт оруулах малын тоо толгойг төлөвлөх	2.3 дугаар улиралд	Сум, багийн Засаг дарга нар МЭҮТасаг	
5	Зэргэлдээ аймаг, суманд мал оторлох, малчдыг нүүлгэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх	Тухайн үед	Сумын Засаг дарга	
Малын эрүүл мэнд, үржлийн ажлын арга хэмжээ				
1	Малын эрүүл мэнд, үржлийн ажлын жилийн төлөвлөгөө, график гарган мөрдөж ажиллах	Жилийн турш	Хувийн МЭ-ийн нэгжүүд	
2	Бог малын хээлтүүлэгчийг ялган суурилж туршлагатай малчинд өгч гэрээгээр маллуулах	1-12 дугаар сард	МЭҮТасаг	
3	Үржлийн малд хяналтын баталгаа хийж гэрчилгээжүүлэх	8,9 дүгээр сард	МЭҮТасаг ААНэгжүүд	
4	Байдраг үүлдрийн цөм сүргийн суурь зохион байгуулах, өрхийн судалгаа хийх	5.6 дугаар сараас	МЭҮТасаг	
5	Бог малын хээлтүүлэг явуулах талаар сумын хэмжээнд баримтлан зөвлөмж гаргах		МЭҮТасаг	
6	МЭ-ийн үйлчилгээний гурвалсан гэрээ байгуулах, гэрээг 11 дүгээр сарын 20 –ны дотор Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнүүлж урамшуулах	1 дүгээр улиралд	Засаг дарга МЭҮТасаг ААНэгжүүд	
7	Малыг амьдаар борлуулах, маханд нядлах борлуулах зах зээлийн талаар санал боловсруулах, баг малчдад хүргүүлж холбогдох дүгнэлт гаргах	Тухайн үед	Сум, багийн Засаг дарга МЭҮТасаг	
8	Аймгаас мал эмнэлгийн үйлчилгээнд шаардагдах эм биобэлдмэл, туулгалт, халдваргүйжүүлэлтийн бодисыг гэрээний дагуу татан авч хуваарийн дагуу тарааж өгөх	Графикт хугацаанд	МЭҮ-ийн тасаг	Баталсан төсвийн хэмжээгээр
9	Мал эмнэлгийн арга хэмжээ тарилга, туулга, боловсруулалт, халдваргүйжүүлэлтийг графикийн дагуу хийж гүйцэтгүүлэх, суурь бүрт хүрч үйлчлэхэд нь хяналт тавих	Графикт хугацаанд	Аж ахуйн нэгжүүд	Санхүүжилтээр

Зун намрын бэлчээрийг хуваарилан зураглал гаргах, ашиглуулах шийдвэр гаргах				
1	Зун, намрын бэлчээрийн ургац тогтоох, ашиглах зураглал гаргах	7,8 дугаар сард	МЭҮТасаг Цаг уурын алба	Өөрийн хүчээр
2	Өвөлжөө, хаваржааны газрыг хортон мэрэгчдээс хамгаалах хялбар арга ажиллагааг төлөвлөх	Эхний хагас жилд	Сум, багийн Засаг дарга МЭҮТасаг, Байгаль хамгаалагч, малчид	Санхүүжилтээр
Ядуу ба чадвар муутай малчин өрхөд туслах, дэмжлэг үзүүлэх				
1	Тусламж, дэмжлэг шаардагдах өрхийн судалгаа гаргах	1,2 дугаар сард	Багийн Засаг дарга нар	
2	Ядуу буюу чадвар муутай малчин өрхөд тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг багийн хэмжээнд зохион байгуулах, малжуулах арга хэмжээ авах	Байнга	Сум, багийн Засаг дарга нар Багийн ИНХурал	
Малын даатгалын судалгаа				
1	МЭД-ын талаар даатгах журам, үнэлгээний мэдээлэл, журам авах	1,2 дугаар улиралд	МЭҮТасаг Даатгалын төлөөлөгч нар	Өөрийн хүчээр
2	Малчдад мэдээлэл хүргэх, даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулах	Даатгалын хугацаанд	МЭҮТасаг Даатгалын төлөөлөгч нар	Өөрийн хүчээр
Сургалт, сурталчилгаа, үзүүлэх сургууль, туршлага судлах, нэвтрүүлэх				
1	Малчдад зориулсан сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах төлөвлөгөө гаргах / малчид жинчдын зөвлөгөөн, сарлагын баяр, шинэ хот айл/	Жилдээ	Сум, багийн Засаг дарга нар МЭҮТасаг	
2	Малчдыг хурал зөвлөгөөн бусад арга хэмжээ, сургалтанд хамруулах	Тухайн үед	Холбогдох албан тушаалтнууд Багийн засаг дарга нар	
Эрсдэл /ган, гандалт, зуд бусад хүндрэл бэрхшээл/-ийн талаар урьдчилан сэрэмжлүүлэх нийтлэг арга хэмжээ:				
1	Дор дурьдсан нөхцөлд зудын эрсдэл тохиолдох магадлал илт нэмэгдсэн, болзошгүй эрсдэлийн эхний шатанд шилжсэн гэж үзэж эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэрэмжлүүлэх арга хэмжээ шуурхай авах. Үүнд: А. Сум бүхэлдээ болон нэг багаас илүү нутаг отрын хугацаанд ган гандалтын ба зудын байдалд орох, орж эхэлсэн болохыг ОБЕГ, аймгийн ОБ хэлтэс, ус цаг уурын асуудал эрхлэсэн эрх бүхий байгууллага албан ёсоор баталж мэдэгдсэн. Б. Баг түүнээс томоохон хэмжээний нутагт байгалийн гэнэтийн аюул тохиолдож гамшгийн байдал бий болсон В. Малчдаас шууд болон багаар дамжуулан өгсөн эзэнтэй албан ёсны батлах үзүүлэлт, тодорхойлолт бүхий мэдээг баг сумаас газар дээр нь хянан тогтоож магадлах, баримтжуулах, шуурхай арга хэмжээ авах			Сумын Засаг дарга Тухайн үед
2	Болзошгүй эрсдэл, цагийн байдлын талаар зарлан мэдээлэх А. Болзошгүй эрсдэлийн урьдчилан сэрэмжлүүлэг гаргах /ус цаг уураас гаргасан урт хугацааны тойм, сарын ба богино хугацааны урьдчилсан мэдээ, урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ/ багийн малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэх Б. Аймгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд болзошгүй эрсдэл, цагийн байдал болон			

	сумаас гаргасан урьдчилан сэрэмжлүүлгийн талаар шуурхай мэдээлэх, багийн хэмжээнд сумаас авах арга хэмжээ аймаг, улсад тавьж шийдвэрлүүлэх		
Тэжээлийн хангамж, нөхөн хангалт:			
1	Тэжээлийн нөхөн хангалт хийх саналыг хянах, шийдвэрлэх, худалдан авах, зээлээр г.м	Сумын Засаг дарга МЭҮ-ийн тасаг	Тухайн үед
2	Сумандаа байгаа тэжээлийн нөөцийг хуваарилах арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих		
3	Шаардлагатай нэр төрлийн тэжээл худалдан авах, нийлүүлэх зах зээлийн судалгаа хийж тэжээлийн нөхөн хангалт хийх /гаднаас худалдан авах, зээлээр нийлүүлэх г.м/ тооцоо, арга хэмжээний санал боловсруулж Засаг даргад хүргүүлэх	Багийн Засаг дарга нар	Тухайн үед
4	Багийн тэжээлийн нөөцийг хуваарилах, сумын ба улсын нөөцөөс авах тэжээлийн төрөл тоо хэмжээг хот айлаар захиалгыг авч нэгтгэн МЭҮТасгийн мал зүйчид хүргэх		

_____ оОо _____



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 19

Жаргалант

Г Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Г
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиглэл бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга	Н.Ганжаргал /ИТХ-ын Төлөөлөгч, Сумын Засаг даргын орлогч/
Нарийн бичгийн дарга	Д.Уранчимэг /ИТХ-ын нарийн бичгийн дарга/
Гишүүд	Ж.Сүхбаатар /Байгаль хамгаалагч/ Д.Дашхүү /ИТХ-ын Төлөөлөгч/ Д.Болормаа /Багш/ О.Нямчаргиа /Иргэн/ П.Батболд /Иргэн/

Хоёр. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зөвлөлийн үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, жилийн эцэст ИТХ-д тайлагнаж байхыг зөвлөлийн даргад даалгасугай.

Гурав. Энэ тогтоол гарсантай холбогдуулж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 05 дугаар тогтоол, 2013 оны 42 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513137

togtool-2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 20

Жаргалант

Хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанас ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 2014 оны 03 дугаар сарын 28 -ны өдрийн 10 цагт хуралдуулсугай.

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийг нөхөн сонгох
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Г.Алтанхуягийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай
3. Сумын 2013 оны төсвийн дансны үлдэгдэл хуваарилах тухай
4. Орон нутгийн хөгжлийн санд тодотгол хийх тухай

Гурав. Хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудлуудыг сайтар бэлтгэн материалыг нэгээс доошгүй хоногийн өмнө төлөөлөгчдөд тараах ажлыг зохион байгуулахыг ИТХ-ын ажлын алба, сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513139
togtool-2014